



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

┌ Спорт хамтлагийг шинэчлэн байгуулах ┐
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Биеийн тамир, спортын газрын 2022 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 2/155 тоот албан бичиг, Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Институтийн биеийн тамир, спортын хамтлагийн үйл ажиллагааг идэвхжүүлж, тэдний идэвх сонирхлыг дэмжих, эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгоор биеийн тамир спорт хамтлагийн бүрэлдэхүүнийг шинэчлэн нэгдүгээр, спортын наадамд оролцох удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Нийслэлийн засаг даргын нэрэмжит нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын IV наадамд ажилтнуудыг идэвхтэй оролцуулж, байгууллагын спортын наадамд оролцох төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Спорт хамтлаг (М.Соёл-Эрдэнэ), Хүний нөөц өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн (Д.Нарантуул) нарт үүрэг болгосугай.

3. Спортын наадамд оролцоход шаардагдах зардлыг тухай бүр төсөв гарган батлуулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу Институтийн 2022 оны үйл ажиллагааны бусад зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (О.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хот төлөвлөлт, судалгааны институтийн даргын 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/10 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа менежментийн хэлтсийн ахлах мэргэжилтэн (М.Отгонцэцэг)-д даалгасугай.

ДАРГА



С.ОЧИР-ЭРДЭНЭ

3150600273